

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр

Тендерийн дугаар: МРЦМ/201906693

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Дорноговь аймгийн Их хэт, Айраг сумдын нутагт орших MV-000159, MV-000160, MV-000161, MV-000163 тоот тусгай зөвшөөрөлтэй “Хамар-Ус”, “Баруун баргын овоо”, “Бортолгой”, “Бужгар” нэрт ордууд, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших MV-000174 тусгай зөвшөөрөлтэй “Бор-Өндөр” ордын 1, 11, 13 дугаар хүдрийн биетийн хаалтын менежмент, нөхөн сэргээлтийн төсөл хийлгэх, тайланг БОАЖЯ, МХЕГ-аар хянуулан батлуулах зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа “Бор-Өндөр” УБҮ-ийн ашиглалт явуулсан MV-000159, MV-000160, MV-000161, MV-000163, MV-000174 тоот тусгай зөвшөөрөлтэй 5 талбайд компанийн хуулиар хүлээсэн үүрэг болон нийгмийн хариуцлагыг биелүүлэх хүрээнд хаалтын менежмент, нөхөн сэргээлтийн төсөл боловсруулж, Байгаль орчны тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн холбогдох журам, стандартад нийцүүлэн боловсруулах, ажлын тайланг байгаль орчны болон хяналт шалгалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагуудын зөвлөмж, зөвшөөрлийг авч батлуулах болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар,
- НӨАТ төлөгчийн гэрчилгээ,
- Нөхөн сэргээлтийн төсөл боловсруулах эрх бүхийг батлах тусгай зөвшөөрлийн хуулбар,
- Сүүлийн 2 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар.

Дээрх баримтууд нь эх хувиараа байх, хэрэв хуулбар хувь бол заавал нотариатаар баталгаажуулсан байх шаардлагатай бөгөөд бүх материалыг pdf файлын хэлбэрт шилжүүлэн тод гаргацтай харагдахаар цахимаар ирүүлнэ.

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2019 оны 09 дүгээр сарын 16–ны өдрийн 17<sup>00</sup> цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2019 оны 09 дүгээр сарын 23–ны өдрийн 09<sup>40</sup> цагаас өмнө дор дурдсан хаягаар ирүүлнэ үү.

**Монгол Улс, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, өөрийн байр**

**Утас: 458401, Факс: 458380** Имэйл хаяг: [mailbox@monros.mn](mailto:mailbox@monros.mn)

**Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.**